

БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ
/2018-2019 оны хичээлийн жил/

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15-р зүйл, Хөдөлмөрийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/197 тоот тушаалаар баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”-ыг баримтлан тус коллежид суралцагч элсүүлэн суралцуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Үлгэрчилсэн журмын дагуу элсэлтийн журмыг жил бүр шинэчлэн боловсруулж, захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулна.
- 1.3. Суралцагч элсүүлэх ажлын гол зорилго нь Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн элсэгчдийн сурах чадвар, мэдлэгийн түвшин, авьяас, төлөвшлийг бодитойгоор үнэлж, цаашид мэргэжлийн ажил хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол, мэдлэг чадвартай хүмүүсийг сонгон элсүүлэхэд оршино.

Хоёр. Элсэгчдэд тавих шаардлага

- 2.1. Техникийн боловсрол олгох сургалтанд элсэгчид нь бүрэн дунд болон мэргэжлийн боловсролтой байх.
- 2.2. Мэргэжлийн боловсрол олгох сургалтанд элсэгчид нь суурь боловсролтой байх.

Гурав. Элсэлтийн зохион байгуулалт

- 3.1. Элсэлтийг захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баталсан элсэлтийн хяналтын тоог баримтлан элсэлтийг зохион байгуулна.
- 3.2. Ажлын хэсгийн дарга гишүүдтэй гэрээ байгуулж ажиллана. Гишүүдийн эрх үүрэг, хариуцлагыг гэрээгээр зохицуулна.
- 3.3. Ажлын хэсгийн үйл ажиллагаа:
 - а. Элсэлтийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна.
 - б. Элсэгчдийг бүртгэж, шалгаруулалтыг ил тод, шударга зохион байгуулна.
 - в. Элсэгчдийг сонгосон мэргэжилд нь элсүүлнэ
 - г. Элсэлттэй холбогдсон санал, гомдлыг цаг тухайд нь барагдуулна.

Дөрөв. Суралцагч элсүүлэх сонгон шалгаруулалт

4.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтанд элсэгчдийг суурь боловсролын гэрчилгээний дүнгийн дундаж онооны дарааллаар нь жагсааж элсүүлнэ.

4.2. Техникийн боловсрол олгох сургалтанд элсэгчдийг Математик, Физикийн хичээлээр шалгалт авч, онооны дарааллаар нь жагсааж элсүүлнэ. Элсэгчдийн шалгалтын оноо тэнцсэн тохиолдолд төгсөлтийн шалгалтын дундаж оноо, бүрэн дунд боловсролын гэрчилгээний дундаж үнэлгээг харгалзан үзнэ.

Тав. Хөнгөлөлттэй нөхцлөөр элсүүлэх

5.1 Мэргэжлийн боловсрол олгох сургалтанд элсэгчид:

5.1.1 9-р ангийг “А” үнэлгээтэй төгсөгчийг шалгалтгүй элсүүлж, мэргэжил сонгуулна.

5.1.2 Улсын олимпиадад 1-3 дугаар байр эзэлсэн элсэгчийг шалгалтгүй элсүүлж, мэргэжил сонгуулна.

5.2 Техникийн боловсрол олгох сургалтанд элсэгчид:

5.2.1 Аймаг, хот, дүүргийн олимпиад, мэргэжлийн ур чадварын уралдаанд оролцож, 1-3 дугаар байр эзэлсэн элсэгчийг шалгалтгүй элсүүлж, мэргэжил сонгуулна.

5.2.2 Мэргэжлийн боловсрол олгох сургалтаас элсэгчид нь сургуулийн олимпиад, уралдаан тэмцээнд 1-3 дугаар байр эзэлсэн, “А” үнэлгээтэй суралцсан бол шалгалтгүй элсүүлж, мэргэжил сонгуулна.

5.2.3 Дээрх хөнгөлөлттэй нөхцлийг нэмэлт бүртгэлийн хугацаанд тооцохгүй.

Зургаа.Бүртгэл

6.1. Элсэгчдийг 6 сарын нэг дэх долоо хоногоос 7 сарын нэг дэх долоо хоногийг дуусталх хугацаанд бүртгэнэ. Нэмэлт бүртгэлийг 8-р сард зохион байгуулна.

6.2. Элсэгчид нь бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

а. Боловсролын үнэмлэх, хуулбарын хамт

б. Хувийн хэрэг

в. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, хуулбарын хамт

г. Хөнгөлөлттэй элсэх нөхцөлд шаардагдах нотлох баримт

д. Бүртгэлийн хураамж

Долоо.Бусад

7.1. Элсэлтийн үед бүрдүүлэх материалыг хуурамчаар бүрдүүлсэн, материал дутуугаас үүсэх хариуцлагыг бүртгүүлэгч хариуцна.

7.2. Элсэлтийн хураамжийг ажлын хэсгийн даргын зөвшөөрлөөр элсэлтийн үйл ажиллагаанд зарцуулж, тайлагнана.

7.3. Суралцагч элсүүлэхдээ энэхүү журамд зааснаас бусад хураамж авахыг хориглоно.